# *ЦАХИМ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН СИСТЕМИЙН ГАРЫН  АВЛАГА*




**Улаанбаатар**

**2025**

# Агуулга:

НЭГ. ШИНЭЭР НЭМЭГДСЭН ЦЭСИЙН ТАНИЛЦУУЛГА .......... 3

ХОЁР. ШИНЭ ЦЭСИЙН ЗААВАР .......... 4

## НЭГ. ШИНЭЭР НЭМЭГДСЭН ЦЭСИЙН ТАНИЛЦУУЛГА

Тус цэсээр тайлангийн мэдээлэл харах дөрөвдөгч байгууллага болох тендерийн компаниудад тухайн ААН-ийн тайлангийн мэдээллийг захирал, удирдлагын зөвшөөрөлтэйгөөр харах, хугацааны тохиргоог хийж цаг хугацааны шалгууртайгаар зөвхөн баталгаажсан тайлан харахаар тохиргоо хийж хөгжүүлсэн болно.

Тус тендерийн газар энэхүү тайлангийн мэдээллийн сервис авахад баазад тохируулагдсан эрхтэй токены сервис болон хүсэлт явуулах болон тайлан харах сервисүүдийг албан бичгээр авах юм. Үүний дараагаар тус сервисээ ашиглан ААН-рүү хүсэлт илгээх бөгөөд ААН-н Захирал эрхтэй хүн зөвшөөрөх үйлдэл хийнэ.

Ингэхдээ хугацааг Захирал эрхтэй хэрэглэгч тохируулж өгөх бөгөөд тухайн хугацаанд тайлангийн үзүүлэлтүүдийг хэдэн ч удаа дуудаж харах боломжтой байна. Энэ үед харилцагч талд тайланг харсан лог бүртгэгдэхгүй дахин дахин мэйл мэдэгдэл очихгүй болохыг анхаарна уу.

## ХОЁР. ШИНЭ ЦЭСИЙН ЗААВАР

Тайлан харах хүсэлтийг зөвхөн ЗАХИРАЛ эрхтэй хүнд **тайлан харах зөвшөөрөл олгох** цэсд харуулна.




Тухайн хэсэгт тайлант үе болон төлвөөр хайх шүүлттэй байна. Хүсэлт гаргасан төлөв default-оор байх бөгөөд энэ хэсэгт шийдвэрлэх хүсэлтүүд харагдана. Ингэхдээ Хүсэлтийн шалтгаан, ямар газраас хэн гэдэг хүн харах мэдээллүүдийг харуулна. Төлвийн ард байрлах батлах товч дарах үед тухайн тайланг хэзээ хүртэл хэдэн цаг хүртэл харуулах огноог сонгох болон тайлбар бичих хэсэг enable байна.

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТӨВ
ISO/IEC 27001:2022




Татгалзах үед **Тайлбар** оруулах хэсэгт нэмж текст бичих боломжтой байна.




Хугацаа дууссан үед дараах жагсаалтад дуусах огноо цагийн хамт харагдана.

